

**“ТУНГАЛАГ ТАМИР” РОМАНД ТУСГАГДСАН
ХУУРЫН ҮЛГЭРИЙГ ШИНЖЛЭХ НЬ**

Цогт, М.Жавхлан

Товч агуулга: Тус өгүүлэлд Монгол улсын төрийн хошой шагналт зохиолч Ч.Лодойдамбын төлөөлөх бүтээл “Тунгалаг Тамир” романд туссан сэлмээр байлдах буюу сэлэм бүжиглэх дүрслэл, ган жадаар дийлээгүй дайсныг гагц бийрээр дийлэх өгүүлэмж, лимбэний эгшгээр дайснаа уяруулан дийлэх өгүүлэмж, бичгийн түшмэл ба цэргийн түшмэлийн дүрслэл, дайнд мордохоос өмнө цэргийн цааз зарлах зэрэг дүрслэл хийгээд өгүүлэмжийг задалж, XX зууны эхний хуурын үлгэр буюу бэнсний үлгэр нь Монголын ард түмний дунд нэлээд их нөлөө тусгалтай байж, Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд ч нөлөөлсөн гэж үзжээ.

Түлхүүр үг: Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир” роман, хуурын үлгэр

Хуурын үлгэр XX зууны Монголын уран зохиолд бага бус нөлөө тусгалтай байсан юм. Энэ тухай Монгол улсын уран зохиол судлаач Б.Мөнхбаяр: “Хорьдугаар зууны монголын уран зохиолд бичгийн зохиолоос үүдэлтэй аман бүтээлийн нөлөө тусгал багагүй байжээ. Тухайлбал төрийн шагналт зохиолч Б.Ринчений “Заан залуудай”, “Их нүүдэл”, Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир”, Д.Маамын “Газар шороо” зэрэг түүх нийгмийн асуудлыг дэвшүүлсэн томоохон романуудад бэнсний үлгэр, хуурын үлгэрийн олон элемент туссаныг харж болно.” (Мөнхбаяр Б. 2018:199) гэж өгүүлсэн байдаг. Тэгвэл Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд хуурын үлгэр нь хэрхэн тусгагдсан байна? гэдгийг энэ өгүүлэлд тодруулан үзвэ. Үүнийг ярихаас өмнө Ч.Лодойдамба хийгээд “Тунгалаг Тамир” романы тухай товч танилцуулъя.

Нэг. Ч.Лодойдамба хийгээд “Тунгалаг Тамир” романы тухай товч танилцуулга

Монгол улсын эрдэмтэд Ч.Лодойдамба хийгээд түүний зохиосон “Тунгалаг Тамир” романы тухай нэлээд олон өгүүлэл зохиол бичиж, зохиогч хийгээд зохиол бүтээлийг танилцуулсан байдаг. Бид тэдгээрийг үндэслэн Ч.Лодойдамба хийгээд “Тунгалаг Тамир” романы тухай товч танилцуулъя.

1.1 Ч.Лодойдамбын тухай товч танилцуулга

БНМАУ-ын Төрийн хошой шагналт (1954-1971) Чадраабалын Лодойдамба (1917. 08. 20-1970. 01. 11) нь 1917 онд Говь-Алтай аймагт төрсөн. Бага наснаасаа сургууль соёлын мөр хөөж, 1954 онд МУИС-ийг төгсөж, улмаар Зөвлөлт Холбоот Улсад аспирантурт суралцан урлаг судлалын ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Тэрбээр 1940 оноос холбооны

техникумд физикийн багш, 1941 онд радио хороонд орлогч дарга, 1944-1945 онд МУИС, Намын Төв Сургуульд түүх, гүн ухааны багш, Монголын Залуучуудын Эвлэлийн Хорооны “Цог” сэтгүүлийн эрхлэгч, 1959 оноос Урлагийн Хэрэг Эрхлэх Хорооны нэгдүгээр орлогч дарга, Соёлын яамны Нэгдүгээр орлогч сайд, Уран сайхны зөвлөлийн даргаар ажиллаж байсан юм.

Ч.Лодойдамба уран бүтээлээ 1940 оноос эхэлж “Алтайд”, “Тунгалаг Тамир” роман, “Манай сургуулийнхан” тууж, “Малгайтай чоно”, “Солонго”, “Дусал нулимс юу гэж хэлсэн бол” зэрэг тууж бичсэнээс гадна “Гарын таван хуруу”, “Өөрийн замаар”, “Итгэж болно” зэрэг жүжиг, “Энэ хүүхнүүд үү” гэх кино зохиол бичжээ. Зохиолчийн “Тунгалаг Тамир”, “Алтайд” гэх роман нь Орос, Чех, Румын, Болгар, Вьетнам, Солонгос, Япон зэрэг хэлээр хэвлэгджээ. Ч.Лодойдамба БНМАУ-ын төрийн шагналыг 1954 онд “Алтайд” роман болон “Манай сургуулийнхан” туужаар, 1971 онд “Тунгалаг Тамир” романаар хоёр удаа хүртсэн юм. Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы кино (1970-1973) хувилбар гарахад кино найруулагч Р.Доржпалам их нэр хүндтэй болсон байна.

1.2 “Тунгалаг тамир” романы тухай товч танилцуулга

Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” роман нийтдээ хоёр боть бөгөөд нэгдүгээр ботийг 1961 онд, хоёрдугаар ботийг 1968 онд хэвлүүлснийг 1971 онд нэгтгэн нэг боть болгон Улаанбаатарт дахин хэвлжээ. Зохиогч Монгол улсын Төрийн шагнал хүртсэн тус шилдэг бүтээлээ “Эцэг Чадраабалдаа зориулжээ”. Тус романд Иргэн улсын цэргийн эрхтэн дархтан, эзэрхэг түрэмгийтэн, дотоодын хар шар феодал, хамжлагын эзэдтэй хуйвалдан Монголын автономит төрийг устгаж, хүн ардыг гал усны гаслан зовлонд учруулж байсныг дүрслэн харуулжээ. Тухайлбал, Бадамдорж шанзав, Иргэн улсын элчин сайд Чинь И, цэргийн харгис эрхтэн Сюй шю жан, Го син лин нар хуйвалдан, худалдаачин Павловынхан баларч, хамаг найдвараа атаман Симонов, Барон унгерн нарт шилжүүлж, Чүлтэм бэйс, Цэвээн тэргүүн мэтийн хамжлагын эздийг гар хөлөө болгож байна. Түүгээр ч үл баран Хатанбаатар Магсаржавыг өөрсдийнхөө хорт бодлогод ашиглах гэж оролдох болно. Гамин, Баронны яргалал, Бадамдорж шанзав, Заяын гэгээний бузар булай хэрэг, ихэс лам нарын хүний үнэргүй шинж, улс орноо өчүүхэн ч бодохгүй байгааг эгэл ард Эрдэнийн ухаарлаар үзүүлэв. Сүхбаатар жанжин Орос улсын тусламжтайгаар хувьсгал хийж байгааг мөнхүү харуулна. Төрийн хэрэгт хамаагүй амь хувиа бодож явсан Гэрэл хүүхэн шиг хүмүүс энэ тэмцэлд хамрагдан амиараа хувьсгалын хэргийг хамгаалах бөгөөд хувьсгал ялсны дүнд ард түмэн төрийн хэргийг боддоггүй байснаа бодох болж, бүх юмыг төр улсын өмнөөс харах хэрэгтэй гэдгийг ухаардаг байна. Нам, төр засгаа Төмөр, Должин, Дулмаа, Долгор, Нямаа зэрэг хүмүүс шиг олон түмнээрээ хүрээлэн, эрх чөлөө зол жаргалаа амь биеэрээ хамгаалагсдын төлөөлөл болгон дүрслэн үзүүлсэн байдаг. Энэ мэтээр үндэстний ухамсар сэргэж, сэргэн мандалтын үзэл санаа нь нийгмийн анги давхаргын бүх хүмүүст нөлөөлж байгааг даян дэлхийн хувьсгалт тэмцэлтэй холбон, түүхэн үнэний дагуу дүрсэлсэн байна.

Тэргүүн бүлэг нь 43 хэсгээс, дэд бүлэг нь мөн 43 хэсгээс бүрэлдсэн түүхэн роман юм. Тус романд нийгэм түүхийн богинохон хугацаа тусгагдсан боловч Монгол улсын хувь заяаны эгзэгтэй үеийг зөвөөр олж сонгон, XX зууны эхний гучаад жилийн Монгол улсын амьдрал тэмцлийн түүхийг БНМАУ байгуулагдсан үеэс эхлээд Дэлхийн I дайн ба Октябрийн социалист их хувьсгалын ялалтын нөлөө, жич 1921 оны Ардын хувьсгалын ялалтын явцтай нягт холбон Тамирын голын нутаг дэвсгэр дээр төвлөрүүлэн үзүүлжээ. Романы хэсэг бүрд нь үйл явдлын өрнөлтийн шинэ өгүүлэмжийг нэмэн хэлхэх аргаар гарган, гол баатрын дүрийг дүрслэн өгүүлсэн бөгөөд зохиомж нь энгийн атлаа их нягт байгууламжтай бичигдсэн нь тэмдэглүүштэй. Зохиолын хэл найруулга уран сайхны дүрслэлтэйгээ нягт зохицсон, дүр бүрийн хэл яриа нь өөрийн ялгалттай бичигдсэн роман билээ.

Хоёр. “Тунгалаг Тамир” романд тусгагдсан хуурын үлгэрийн нөлөө

Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд хуурын үлгэрийн нөлөө нэлээд хэдэн талаар тусгагдсан байдаг. Түүнийг доорх мэт хэдэн талаар өгүүлж болно:

2.1 Сэлмээр байлдах буюу сэлэм бүжиглэх дүрслэл

Хуурын үлгэрт сэлмээр байлдах буюу сэлэм бүжиглэн тоглох дүрслэл олонтоо тохиолддог. Жишээлбэл: Өвөр Монголын Түшээт нутагтай алдарт хуурч Бүрэнбаяр (1928-1985)-аас: “за, Ү зи шой сэлмийг атгаж, Ү ван болон Шюй шигийн өмнө зэвсгийг бүжиглэж баруун гарын сэлэм зүүн суганы доогуур сур хэмээн гарч, зүүн гарын сэлэм баруун гарын дээгүүр гялбас гэж харагдмагц хоёр сэлэм нэг сүлжилдэн сэлмийн гэрэл гялав галав татаад сэлмийн эрдэм улираад ирлээ. Дээр гурав, доор дөрөв, зүүн тав, баруун зургаа, өмнө долоо, хойд найм, биеийг тойроод сэлмийн хүрээ татаад ирлээ. Борвиор урваж богтсоороо суугаад, доор доороо урваж хөрвөөд, эргэж тойроод ирж байх, жавар салхи хурайлаад ирж байх нэгэн лүгээ болж, бүлэг бүлэг Ү шян бөгийн бие үзэгдэхгүй, сэлмийн уул босчихсон адил гялав галав гэгээн гэрэл сацраад, Ү зи шой алхаж гишгээд явахын үед гутлын ул нь байн байн нэг цайлс цайлс харагдана. Түүнээс өөр бие болбол нэг ч үзэгдэхгүй. Шюй ши ли лөү (асар)-гийн цонхоор гадагшаа бараа хараад баруун гараараа түүшээ тулаад бараа харах нүд дотогшоо шинжээд Ү зи шюйгийн сэлмийн жаварт хоёр талын цохны гижиг илбэс илбэс хацрыг нь даган хийсээд туар чимэг (засал чимэглэл) нь бол сэлмийн жаварт сэнжилж хөдлөөд, дотроо бодно. Шюй ши ли: Үнэхээр дэлхий дахинд хосгүй нэр гарсан хэмээвч болох л хүн ээ”¹ хэмээн Ү зи шюйгийн сэлэм бүжиглэснийг дүрсэлсэн юм. Дээрхтэй адилаар “Тунгалаг тамир” романд: “Манай энэ нөхөр бол сэлмийн эрдэмд хосгүй хүн. Ёстой сэлэм гялс, толгой бөндгөс гэж цавчина даа. Нэг цавчихдаа гурван толгой бөндийтөл нь аваад тэр тэнд өнхрүүлж орхидог эр дээ. Сэлэм эргүүлж байхад бие нь нэг бөөрөнхий хөх юм л харагддаг.” (Лодойдамба, 1986:489) хэмээн дүрсэлжээ. Дээрх хоёр дүрслэл адил тал байх мөртөө адил бус тал ч байдаг. Адил тал нь хоёр зүйл байна. Нэг нь сэлмийн гялс гэж харагдаж байх дүрслэл болно. Нөгөө нь сэлэм бүжиглэж байхад бүх бие нь үзэгдэхгүй болох дүрслэл болно. Даруй “Тунгалаг тамир”-т дүрслэгдсэн “Сэлэм эргүүлж байхад бие нь нэг бөөрөнхий хөх юм л харагддаг” хэмээх дүрслэл хийгээд хуурын үлгэр дэх уламжлалт дүрслэл “бүлэг бүлэг Ү шян бө-гийн бие үзэгдэхгүй, сэлмийн уул босчихсонд адил, гялав галав гэрэл сацраад, Ү зи шюй алхаж гишгээд явахын үед гутлын ул нь байн байн нэг цайлс цайлс харагдана, түүнээс өөр бие болбол нэг ч үзэгдэхгүй” хэмээх дүрслэл болно. Дээрх харьцууллаас мэдэж болох нь “Тунгалаг тамир”-ын зохиогч Ч.Лодойдамба гуай хуурын үлгэр дэх сэлэм бүжиглэх буюу сэлмээр байлдах дүрслэлийн нөлөөгөөр дээрх дүрслэлийг зохиож үлгэр үйл явдалтайгаа уусгасан байна.

2.2 Ган жадаар дийлээгүй дайсныг хулсан бийрээр дийлэх өгүүлэмж

Хуурын үлгэрт ган жадаар дийлээгүй хэцүү дайсныг хулсан бийрээр дийлэх үйл явдал үргэлж тохиолддог. Жишээлбэл: “Гурван улсын үлгэр” дэх Зү гэ лян бол даруй билиг оюун, бичиг эрдмээр онцгойрсон бичгийн эрдэмтэн байж, олон удааны дайнд ган жадаар дийлээгүй дайсныг бичгийн эрдэм, арга ухаанаараа дийлж, дайны гавьяа байгуулдаг.

“Тунгалаг Тамир” роман ч хуурын үлгэрийн энэхүү илтгэх аргын нөлөөг хүртсэн байна. Жишээлбэл тус романд: “Таржаа чи өчүүхэн гавьяандаа эрдээд дэгдэж байна. Эртэн баатар ган жадаар дийлээгүй юмыг эрдэмтэй мэргэд хулсан бийрээр дийлнэ гэсэн юм шүү гэж Довчин хэдэн жилийн өмнө цахар хуурчаас сонссон үгээ хэлж орхив” (Лодойдамба Ч. 1986:244-246;307-355) хэмээх нэгэн хэсэг өгүүлэмж байдаг. Эндээс хоёр зүйлийн утга санааг мэдэж болно.

¹ Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Ү юэ чүн чю” (越春秋) хэмээх хуурын үлгэрийн шингээлтийн хоёрдугаар бүлгийн 37-39 дүгээр минутад.

Нэгд: Бие баатраас билиг баатрыг эрхэмлэсэн сургаал. Чингисийн билиг сургаалд “Бие баатар болбоос нэгэн үеийн баатар, билиг баатар болбоос түмэн үеийн баатар” хэмээх үг байхад монгол зүйр сэцэн үгэнд ч “Хүчээр мянган жинг өргөхөд, аргаар түмэн жинг өргөнө” хэмээх үг байдаг. Энэ нь арга ухааныг хар хүчээс илүү эрхэмлэсэн явдал болох юм. “Тунгалаг Тамир” романд ярьсан “Эртэн баатар ган жадаар дийлээгүй юмыг эрдэмтэй мэргэд хулсан бийрээр дийлнэ” гэдэг нь мөн түүний ондоо нэг зүйлийн илтгэх арга болох нь гарцаагүй, гэхдээ энд бичиг эрдмийг илүү чухалчлав.

Хоёрт: Цахар хуурчийг онцгойлон товойлгосон. Өвөр Монгол оронд хамгаас алдартай хуурч нь Жирэм аймаг, Зуун-Уд аймаг ба Хянган аймгийн хуурчид болно. Цахар аймгаас хэдийгээр Донид, Лувсан, Доржхуяг, Насан зэрэг хуурч гарсан ч энэ бол сүүлийн үеийн учир болох юм. Ч.Лодойдамба гуай цахар хуурчаас хуурын үлгэр сонсож байснаас үзэхэд, тухайн үед цахарт хуурч байсан мөртөө тэдний зарим нь Монгол улсад очиж хуурын үлгэр хэлдэг байжээ. Үүнээс “Тунгалаг Тамир”-ын зохиогч тус хуурчийн хэлсэн утга учиртай өгүүлэмжийг уул зохиолд шингээн хэрэглэж уран бүтээлээ нэн илүү урлагжуулан сайжруулжээ.

2.3 Лимбэний эгшгээр дайсныг уяруулж дийлэх өгүүлэмж

Хуурын үлгэр буюу бэнсний үлгэрт уяруун дуу хоолой буюу хөгжмийн эгшгээр дайсан этгээдээ уяруулж, байлдах цөс зориг ба эрч хүчийг нь мохоон дайны ялалтыг олох өгүүлэмж тааралддаг. Жишээлбэл, хуурын үлгэр “Баруун Хань улсын үлгэр”, эсвэл бэнсний үлгэр “Баруун Хань улсын үлгэр”-ийн 14-р дэвтэрт Хань улсын Жан лян жанжин лимбэ үлээж Шян юйгийн найман мянган цэргийг ухруулах өгүүлэмж гардаг. Тус үлгэрт Лю бан хэмээн Шян юйг Гай шягийн газар бүсэлж авсан боловч найман мянган Чу улсын цэрэг түүнийг хамгаалж байх мөртөө амуу өвс элбэг байж, хатуугаар байлдахад хүрвэл Лю бангийн цэргийн үрэгдэл ч хүнд ноцтой болох юм. Энэ үес Лю бангийн зөвлөлийн сайд Жан лян: Чу улсын цэрэг олон жилийн турш Шян юйг даган эл газар байлдаан хийж явахдаа гэр нутаг, аав ээж, ах дүү нараа лавтай санажээ. Онцгойлон хүнд бүслэлтийн дор гарах замаа олохгүй болсон үед нэн илүү санах болно. Хэрвээ тэд нарын нутгаа мөрөөдөх сэтгэлийг нь хөдөлгөвөл байлдахгүйгээр дийлж болно гэсэн байна. Иймээс Жан лян лимбээр Чу улсын аяаг үлээж, Хань улсын цэргүүд бас Чу улсын хэлээр дуулснаас Чу улсын цэрэг гэр орон элгэн саднаа санаж, илд зэвсгээ хаяад орж өгсөн бөгөөд Шян юй бас хүзүүгээ огтлоод үхсэн байна. Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд ч Жан мин хэмээх лимбэ шиг хоолойтой хүний дүр илэрчээ. Түүнд: “Жан мин (хятадын эртний романы баатрын нэр)-гийн лимбэ шиг хоолойтой хүн юм гэж Чулууныг хэлэхэд итгэлт Жан мин гэж юу байдгийг огт сонсоогүй боловч ‘Яг тийм шүү. Та ёстой нэг онож хэллээ гээд нарийхан дуугаар инээв’ (Лодойдамба Ч. 1986:244-246;307-355) хэмээн тэмдэглэсэн байна. Энд дурдсан Жан мин гэдэг нь ямар жанжин болох, ямар үлгэрт гарах, ямар үйл явдалд хэрхэн лимбэ үлээсэн тухай Хятадын эртний романаас эрж олоогүй. Бид хуурын үлгэр “Баруун Хань улсын үлгэр”, эсвэл бэнсний үлгэр “Баруун Хань улсын үлгэр”-ийн арван дөрөвдүгээр дэвтэрт лимбэ үлээн Шян юйгийн цэргийг ухруулсан Жан лян-гийг Жан мин хэмээн бичсэн болов уу хэмээн таамаглаж байна. Учир нь овог нь адил, нэрийн хамаг сүүлчийн авиа “н” нь ч адил. Эсвэл уран зохиол тул зохиогч Ч.Лодойдамба зориудаар “Жан лян”-г “Жан мин” хэмээн өөрчилсөн ч магад. Юу ч гэсэн зохиогчоос хуурын үлгэр буюу бэнсний үлгэрээс сэдэв өгүүлэмж авч, өөрийн романаа урлагжуулан баяжуулж байсан нь илэрхий. Энэ бол даруй хуурын үлгэр буюу бэнсний үлгэрээс Монголын орчин үеийн уран зохиолд үзүүлж байсан нөлөө тусгал болох юм.

2.4 Бичгийн түшмэл ба цэргийн түшмэл

Хуурын үлгэр буюу бэнсний үлгэр дэх хаан эзэн нь бүр бичгийн түшмэл хийгээд цэргийн түшмэлтэй байж, хаан эзэн чао хурахад (хурал хуралдах) бичгийн түшмэл нь зүүн гар талд зогсож, цэргийн түшмэл нь баруун гар талд зогсдог. Тиймээс хуурч нар хаан эзэн чао хурахад:

“Чимэгт баруун индрээр
Цэргийн түшмэл зогсолцоно
Шилдэг дайчин гавьяатай
Чинь ван түшмэд тэргүүлнэ.
Бие залгаад зүүнээр
Бичгийн түшмэд жигүүрлэнэ,

Билигт чөншян (чинсан-дундад улсын эртний түшмэлийн зэрэг) тэргүүлнэ.” (Рэнцэндорж. Хувьт. 1988:55-56;235-236) хэмээн дүрсэлдэг. Үүнтэй адилаар “Тунгалаг тамир” романд ч бичиг цэргийн түшмэлийн тухай тэмдэглэн оруулсан байдаг. Түүнд: “Төр бол хоёр баганатай байдаг. Нэг нь бол бид ван, бэйл, бэйс, гүн зэрэг бичиг цэргийн түшмэд, нөгөө нь гэвэл хутагт хувилгаан, хамба цорж зэрэг санваартан лам нар болохоор төрийн баганыг бид хамт түшилцэх ёстой билээ гэж Довчин мэдэмхий хэлжээ. Лам нар төрийн төлөө залбирч л байвал дээр. Хоёр багана байдаг юм бол нэг нь бичгийн түшмэд, нөгөө нь цэргийн түшмэд, өөр багана байхгүй гэж Чулуун хэлжээ. ” (Лодойдамба Ч. 1986:244-246;307-355) гэж тэмдэглэсэн байна. Дээрхээс үзэхэд Чулуун хэмээх зохиолын дүр төр гүрэнд бичгийн түшмэд хийгээд цэргийн түшмэд байхыг зөвшөөрсөн боловч Довчингийн хэлсэн лам нарыг төр гүрний тулгуур баганад үзээгүй. Энэ нь мөн хуурын үлгэр буюу бэнсний үлгэрт хэлдэг улс гүрний тулгуур багана болсон бичгийн түшмэл ба цэргийн түшмэлтэй яв цав тохиролцсон байна. Тиймээс үүнийг мөн хуурын үлгэрийн нөлөөгөөр бичжээ гэж бид үзэж байна.

2.5 Цэргийн цааз зарлах өгүүлэмж

Хуурын үлгэрт дайн байлдаанд мордохоос өмнө цэргийн цааз зарлаж, хууль ёсыг чангаруулах өгүүлэмж үргэлж тохиолддог. Жишээлбэл, Ү.Дорж хуурч:

“Агт хүлэг мориндоо сайн
Атгаад тэгсэн (атгасан) зэвсэгтээ сайн
Албан цэргийн цааздаа сайн
Алагдахаас айхгүй зориг нь сайн
Хүлэг унаа морь нь сайн
Хэрэглээд тээх зэвсэг нь сайн
Хуяг дуулга аль нь ч сайн
Хортноос айхгүй зориг нь сайн.
Ийм цэргийг арван түм салгаж
Эрхэм Юаньшуай зарлиг буулгалаа:
Түрүү бууд ирэхгүй бол
Хүнд дөчин мод занчина
Хоёрдугаар бууд ирэхгүй бол
Хүнд ялаар наян мод занчина
Гуравдугаар бууд ирэхгүй бол
Тэргүүнийг нь цавчиж шийтгэх болно
Санаа дураараа аашилж болохгүй
Цааз ёсыг зөрчиж болохгүй
Хуяг цэрэг гэдэг чинь болбол

Хутган ирнээс хурц цаазтай юм” (Рэнцэндорж, Хувьт. 1988:55-56:235-236) хэмээн цэрэг жагсаан цааз зарласан талаар хуурджээ. “Тунгалаг Тамир”-т бас үүнтэй адилаар: “□За та минь эсрэгцвэл цохилно шүү гэж Бадарч түмэн цэргийн жанжин их тулалдаанд орохын өмнө цэрэгтээ тушаал өгч байгаа дуугаар хэлээд мориндоо мордов. ” (Лодойдамба Ч. 1986:244-246-307-355) хэмээн товч хураангуйгаар хэлсэн байна. Энд хэдийгээр Ү Доржийн хэлсэн шиг арван түмэн цэрэг хэмээн өгүүлсэнгүй боловч түмэн цэрэг хэмээсэн нь мөн хуурын үлгэр дэх дүрслэлтэй их л ойрхон, дахивал хуурын үлгэрт мөн түм буюу мянгаар цэрэг жагсааж, цааз зарлах явдал ч үргэлж тохиолддог. Тиймээс энд өгүүлсэн “Түмэн цэргийн жанжин их

тулалдаанд орохын өмнө цэрэгтээ тушаал өгч” байгаа өгүүлэмж нь хуурын үлгэрийн цэрэг жагсааж цааз зарлах өгүүлэмжээс ирэлтэй зүйл болно

Дээр ярьсан зүйлийг хураангуйлбал: БНМАУ-ын Төрийн хошой шагналт Ч.Лодойдамбын төлөөлөх бүтээл “Тунгалаг Тамир” романд хуурын үлгэр буюу бэнсний үлгэрийн нөлөө нэлээд олон талаар туссан байдаг. Түүнд хуурын үлгэрт үргэлж гардаг сэлмээр байлдах буюу сэлэм бүжиглэх дүрслэл, ган жадаар дийлээгүй дайсныг гагц бийрээр дийлэх өгүүлэмж, лимбэний эгшгээр дайсан этгээдээ уяруулан дийлэх өгүүлэмж, бичгийн түшмэл ба цэргийн түшмэлийн дүрслэл, аян дайнд мордохоос өмнө цэргийн цааз зарлах өгүүлэмж зэрэг дүрслэл хийгээд өгүүлэмж, жич Цахар хуурчийн дүр дүрслэл ч илэрсэн байна. Эдгээр нь XX зууны эхэнд хуурын үлгэр буюу бэнсний үлгэр нь Монгол улсын ард түмний дунд нэлээд их нөлөө тусгалтай байсныг харуулжээ. Энэ нь Өлзийн Лувсан (1885-1943), Энх (1912-1966), Самбуудаш, Т.Сэнгэ зэрэг хуурч урлагчин, жич Цахар, Хишигтэн, Шилийн гол зэрэг газар орноос Монголд очсон хуурч нар үлгэр холбоо хэлж, хятад үндэстний үлгэр урлагийг Монгол улсын ард түмний дунд монголжуу үлгэр болгон уламжилж байсны тусгал болох юм.

THE INFLUENCE OF HUURIN-ULIGER ON THE MONGOLIAN NOVEL *THE CLEAR RIVER OF TAMIR*

This paper studies the examples of Huurin-uliger motives and scenes in the well-famed Mongolian novel *The Clear River of Tamir* by the national-award writer Ch. Lodoidamba from Mongolia. Through an analysis of the motif and scenes such as sword battle or sword dance, winning the fierce enemy with clever tricks, playing flute and moving the enemies, description of civil servants and military attachés, announcement of military laws before military expedition and so on, the paper concludes that the Huurin-uliger or Bensen-uliger has great influence among the people of Mongolia, which has been reflected in the Ch. Lodoidamba's novel.

Key words: Ch.Lodoidamba; *The Clear River of Tamir*; *Huurin-uliger*

Номзүй

- Мөнхбаяр Б.** 2018. *Монголын орчин үеийн уран зохиолд үзүүлсэн бэнсний үлгэр ба хуурын үлгэрийн нөлөөллийн асуудалд*. Дархан хуурч Эрдэнэзүрхийн мэндэлсэн 100 жилийн ойг дурсгах хуурын үлгэрийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын өгүүллийн эмхэтгэл. Дотоод материал.
- Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Ү юэ чүн чю” (吴越春秋) хэмээх хуурын үлгэрийн шингээлт.
- Лодойдамба Ч.** 1986. *Тунгалаг Тамир* (дээд, доод дэвтэр). Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.
- Рэнцэндорж, Хувьт** найруулав. 1988. *Хуурын үлгэрийн хэвшсэн хэллэг*. Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.
- Цогт.** 2002. *Хуурын үлгэрийн судлал*. Үндэстний хэвлэлийн хороо.
- Цогт.** 2019. *Уламжлал ба хөгжил: Монгол утга зохиолын шинэ судлал*. УБ.